

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2024/23/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл.....	5-9
3. Аудитын илрүүлэлт .....	14
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	15

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.15 № 296

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ч.ГАНБАТ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 561 дугаар тогтоолоор дулаан түгээх, дулаан хангах үйл ажиллагааны халаалт, халуун ус, халаалтын суурь үнэ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2022 оны 186 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны тарифт өөрчлөлт орсон байна.

### Аудитын гол асуудал

Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь 2005 онд Азийн хөгжлийн банкнаас авсан зээлийн үлдэгдэл 1,449.3 сая төгрөг байна. Тайлант онд зээлийн хүүгийн төлбөрт 1,623.3 сая төгрөгийг төлсөн байна.

011021154

### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн ИТХ-ын 2023 оны 09/03 дугаар тогтоолоор "Дорнод Нийтийн Аж Ахуй" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хүн томилсон байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2023 оны 1 сарын 1	2023 оны 12 сарын 31
<b>1.1.01</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</b>	<b>777,525,327.25</b>	<b>730,665,293.99</b>
1.1.02	Дансны авлага	565,389,394.92	511,824,658.20
1.1.06	Бараа материал	129,462,051.52	105,674,336.09
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,800,000.00	13,300,000.00
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	4,272,727.23
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,477,176,773.69	1,365,737,015.51
1.2.01	Үндсэн хөрөнгө	16,151,728,881.90	17,836,688,507.77
1.2.02	Биет бус хөрөнгө	3,811,812,666.65	3,807,937,666.61
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,963,541,548.55	21,644,626,174.38
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,440,718,322.24</b>	<b>23,010,363,189.89</b>
2.1.1.01	Дансны өглөг	175,437,856.68	73,736,870.47
2.1.1.03	Татварын өр	62,573,974.87	176,790,583.82
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	9,758,855.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	238,011,831.55	260,286,309.29
2.1.2.01	Урт хугацаат зээл	1,758,342,143.00	0.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	1,314,373,518.44	1,449,384,807.06
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,072,715,661.44	1,449,384,807.06
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,310,727,492.99</b>	<b>1,709,671,116.35</b>
2.3.01	Өмч: - төрийн	467,926,157.11	467,926,157.11
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,194,607,800.73	3,194,607,800.73
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	15,750,258,031.84	17,580,345,608.40
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,282,801,160.43	57,812,507.30
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-146,717,186.65
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,282,801,160.43	204,529,693.95
2.3.11	Эздийн өмчийн дүн	18,129,990,829.25	21,300,692,073.54
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>21,440,718,322.24</b>	<b>23,010,363,189.89</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,381,632,181.82	4,789,889,078.72
02	Борлуулалтын өртөг	3,917,113,389.64	4,860,730,641.92
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>-535,481,207.82</b>	<b>-70,841,563.20</b>
08	Бусад орлого	174,774,771.45	2,076,740,244.39
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>174,774,771.45</b>	<b>2,076,740,244.39</b>
10	Ерөнхий ба удирдлагын зардал	244,427,151.10	193,559,666.38
12	Бусад зардал	227,003,666.26	1,919,955,182.83
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>471,430,817.36</b>	<b>2,113,514,849.21</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	135,873.60	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	-81,236,053.12	-39,101,018.63
17.1	Олз, гарзын дүн	-81,100,179.52	-39,101,018.63
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>-913,237,433.25</b>	<b>-146,717,186.65</b>
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-913,237,433.25	-146,717,186.65
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>-913,237,433.25</b>	<b>-146,717,186.65</b>

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Мөрийн	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,461,010,378.21</b>	<b>6,816,540,788.31</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,250,325,125.92	6,608,537,911.71
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	64,000,000.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	146,685,252.29	208,002,876.60
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>7,165,104,246.77</b>	<b>6,863,400,821.57</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,592,609,123.40	1,862,349,223.95
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	508,819,223.06	585,137,584.84
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,142,648,623.50	1,104,386,363.75
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	296,056,726.79	305,471,968.48
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	199,766,274.00	271,900,658.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	300,000,000.00	136,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	384,837,521.96	390,065,409.32
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,402,125.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,731,964,629.06	2,208,089,613.23
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-1,704,093,868.56</b>	<b>-46,860,033.26</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	135,873.60	0.00
3.1.4	Бусад	135,873.60	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	135,873.60	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-1,703,957,994.96	-46,860,033.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,481,483,322.21	777,525,327.25
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	777,525,327.25	730,665,293.99

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	11,363,410,017.84	-1,865,254,927.18	13,160,689,048.50
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны	0.00	0.00	0.00	1,495,691,200.00	1,495,691,200.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-913,237,433.25	-913,237,433.25
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	4,386,848,014.00	0.00	4,386,848,014.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	15,750,258,031.84	-1,282,801,160.43	18,129,990,829.25
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны	0.00	0.00	0.00	1,487,330,854.38	1,487,330,854.38
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-146,717,186.65	-146,717,186.65
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	1,830,087,576.56	0.00	1,830,087,576.56
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	467,926,157.11	3,194,607,800.73	17,580,345,608.40	57,812,507.30	21,300,692,073.54

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>4,515,809,300.00</b>	<b>5,229,645,000.00</b>	<b>713,835,700.00</b>	<b>116%</b>
<b>Үйл ажиллагааны орлого</b>		<b>4,400,073,600.00</b>	<b>4,789,889,000.00</b>	<b>389,815,400.00</b>	<b>109%</b>
1	ААНБ-д цэвэр ус түгээх үйлчилгээ	933,062,000.00	1,000,095,500.00	67,033,500.00	107%
2	Айл өрхөд цэвэр ус түгээх үйлчилгээ	936,960,300.00	911,669,600.00	(25,290,700.00)	97%
3	Гэр хороололд цэвэр ус түгээх үйлчилгээ	113,376,000.00	108,677,100.00	(4,698,900.00)	96%
4	Цэвэр усны суурь хураамж	277,002,500.00	301,099,400.00	24,096,900.00	109%
5	ААНБ-аас бохир ус татан зайлуулах үйлчилгээ	734,606,700.00	820,598,500.00	85,991,800.00	112%
6	Айл өрхөөс бохир ус татан зайлуулах үйлчилгээ	815,587,000.00	786,056,400.00	(29,530,600.00)	96%
7	ААНБ-ийн дулаан дамжуулан түгээх үйлчилгээ	164,091,700.00	304,872,000.00	140,780,300.00	186%
8	Айл өрхийн дулаан дамжуулан түгээх үйлчилгээ	207,555,600.00	273,221,500.00	65,665,900.00	132%
9	ХХУ дамжуулан түгээх үйлчилгээ	81,859,500.00	92,085,500.00	10,226,000.00	112%
10	Дулааны суурь хураамж	65,972,300.00	82,769,800.00	16,797,500.00	125%
11	Бусад орлого	70,000,000.00	108,743,700.00	38,743,700.00	155%
<b>Үйл ажиллагааны бус орлого</b>		<b>115,735,700.00</b>	<b>439,756,000.00</b>	<b>324,020,300.00</b>	
1	Хүү, торгуулийн арга хэмжээ	61,500,000.00	75,696,100.00	14,196,100.00	123%
2	Засвар үйлчилгээний орлого	24,935,700.00	6,071,400.00	(18,864,300.00)	24%
3	Байр ашиглуулсаны хөлс	9,300,000.00	10,488,000.00	1,188,000.00	113%
4	Бусад	20,000,000.00	347,500,500.00	327,500,500.00	
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>5,236,404,454.26</b>	<b>5,376,362,186.57</b>	<b>139,957,732.31</b>	<b>103%</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>		<b>4,669,172,900.00</b>	<b>4,860,730,686.57</b>	<b>191,557,786.57</b>	104%
1	Цалин хөлс	2,260,364,800.00	2,237,112,800.00	(23,252,000.00)	99%
2	Ажил олгогчоос олгох ЭМД, НДШ	306,232,800.00	298,926,400.00	(7,306,400.00)	98%
3	Цахилгаан	462,277,200.00	393,848,100.00	(68,429,100.00)	85%
4	Дулаан	33,056,200.00	25,051,700.00	(8,004,500.00)	76%
5	Нүүрс	22,000,000.00	18,033,800.00	(3,966,200.00)	82%
6	Тээврийн зардал	8,000,000.00	11,022,100.00	3,022,100.00	138%
7	Шатахуун, ШТМ	233,413,300.00	244,673,400.00	11,260,100.00	105%
8	Хөрөнгийн элэгдэл	650,000,000.00	1,053,540,644.61	403,540,600.00	162%
9	Урсгал засвар	217,000,000.00	208,748,500.00	(8,251,500.00)	96%
10	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зардал	150,187,600.00	122,565,300.00	(27,622,300.00)	82%
11	Бичиг хэрэг	3,145,000.00	6,466,400.00	3,321,400.00	206%
12	Холбоо	25,283,000.00	24,826,500.00	(456,500.00)	98%
13	Материал түүхий эд худалдан авах	205,000,000.00	98,509,900.00	(106,490,100.00)	48%
14	Албан томилолт	10,449,000.00	10,412,200.00	(36,800.00)	100%
15	Аваарын нөөц	19,880,000.00	19,880,000.00	-	100%
16	Бусад зардал	62,884,000.00	87,112,941.96	24,228,941.96	139%
<b>Удирдлагын зардал</b>		<b>185,941,000.00</b>	<b>193,559,600.00</b>	<b>7,618,600.00</b>	<b>104%</b>
1	Цалингийн зардал	83,543,800.00	84,416,300.00	872,500.00	101%
2	ЭМД, НДШ-ийн зардал	10,194,700.00	11,526,700.00	1,332,000.00	113%
3	ТУЗ-ын урамшуулал	30,240,000.00	30,030,000.00	(210,000.00)	99%
4	ТУЗ-ын ЭМД, НДШ	4,021,900.00	3,893,100.00	(128,800.00)	97%
5	Бичиг хэрэг	1,368,000.00	438,300.00	(929,700.00)	32%
6	Шатахуун	8,000,000.00	10,058,500.00	2,058,500.00	126%
7	Хөдөлмөр хамгаалал	1,290,000.00	155,400.00	(1,134,600.00)	12%
8	Холбоо	475,200.00	338,000.00	(137,200.00)	71%
9	Хөрөнгийн элэгдэл	27,000,000.00	29,585,400.00	2,585,400.00	110%
10	Урсгал засвар	3,500,000.00	8,045,500.00	4,545,500.00	230%
11	Материал түүхий эд	2,500,000.00	1,703,900.00	(796,100.00)	68%
12	Албан томилолт	6,269,400.00	6,205,000.00	(64,400.00)	99%
13	Бусад зардал	2,500,000.00	2,125,500.00	(374,500.00)	85%
14	ТУЗ-ын бусад зардал	5,038,000.00	5,038,000.00	-	100%

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Үндсэн бус үйл ажиллагааны зардал		381,290,554.26	322,071,900.00	(59,218,654.26)	84%
1	Буцалгүй тусламж	10,000,000.00	7,000,000.00	(3,000,000.00)	70%
2	Ахмадын сан	15,000,000.00	15,609,900.00	609,900.00	104%
3	Шагналын сан	7,000,000.00	6,842,600.00	(157,400.00)	98%
4	Тэтгэвэрт гарах ажилчдын тэтгэмж	116,870,554.26	52,516,300.00	(64,354,254.26)	45%
5	Мэдээлэл, Зар сурталчилгаа, хэвлэл, гишүүний татвар	18,400,000.00	18,448,900.00	48,900.00	100%
6	Ажлын хөлсний урамшуулал	40,000,000.00	34,090,000.00	(5,910,000.00)	85%
7	Гадаад арга хэмжээ /сургалт, танилцах аялал/	23,000,000.00	23,336,200.00	336,200.00	101%
8	Сургалтын зардал	11,000,000.00	10,969,200.00	(30,800.00)	100%
9	Биеийн тамир, урлаг соёлын арга хэмжээ	9,700,000.00	9,287,300.00	(412,700.00)	96%
10	Дотоодын цэргийн тусгай салааны зардал	10,600,000.00	10,062,100.00	(537,900.00)	95%
11	Бусад	10,000,000.00	61,905,800.00	51,905,800.00	619%
12	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	23,000,000.00	20,669,300.00	(2,330,700.00)	90%
13	Аудитын хөлс	2,000,000.00	2,500,000.00	500,000.00	125%
14	Программын лицензийн төлбөр	1,500,000.00	1,500,000.00	-	100%
15	Гамшгаас хамгаалах эрсдийг бууруулах арга хэмжээний зардал	10,000,000.00	5,819,300.00	(4,180,700.00)	58%
16	НАА-н спортын арга хэмжээ	5,900,000.00	5,879,000.00	(21,000.00)	100%
17	Ажиллагсадын хоолны зардал	67,320,000.00	35,636,000.00	(31,684,000.00)	53%
<b>НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ</b>		<b>(720,595,154.26)</b>	<b>(146,717,186.57)</b>	<b>573,877,967.69</b>	<b>20%</b>
Зөврийн усны алдагдалыг нөхөх орлого		64,000,000.00		(64,000,000.00)	0%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>		<b>(656,595,154.26)</b>	<b>(146,717,186.57)</b>	<b>509,877,967.69</b>	<b>22%</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

#### **Залруулсан алдаа:**

Байгууллагын эзэмшлийн 2106044903 гэрчилгээтэй 150м<sup>2</sup> газрыг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС-17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.

Аудитаар нийт 309.7 сая төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 246.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 63.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллалаа.

#### 3.1 Албан шаардлага

##### **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.**

Тайлант онд 246.2 сая төгрөгийн худалдан авалтыг хуульд заасны дагуу худалдан авах сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Биет бус хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 48.2 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэн 15.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

тооцон зардлаар бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, ангилал, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийг шинж чанараар нь үнэн зөв ангилан бүртгэл, тайланд тусгах.

**2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгох.

**3. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Дорнод аймгийн ИТХ-ын 2023 оны 09/03 дугаар тогтоолоор "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хүн томилогдсон нь Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.1.7 дахь "төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх" гэсэн шаардлагыг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Аймгийн ИТХ-д "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-д заасан шаардлагад нийцүүлэн томилох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагын эзэмшлийн 1 газрыг бүртгэл тайланд тусгаагүй	1	3,750.0	1	3,750.0	-	-	1	3,750.0	-	-	--	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,750.0</b>	<b>1</b>	<b>3,750.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>3,750.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>--</b>

**“Дорнод Нийтийн Аж Ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Биет бус хөрөнгийн шинж чанартай 6 нэр төрлийн 48.2 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансад бүртгэн 15.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцон зардлаар бүртгэсэн байна.	1	63,447.3	-	-	-	-	1	63,447.3	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>63,447.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>63,447.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
-	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Тайлант онд 246.2 сая төгрөгийн худалдан авалтыг хуульд заасны дагуу худалдан авах сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулан авсан байна.	1	246,217.1	-	-	1	246,217.1	-	-
Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй 23 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй байна	1	0	-	-	-	-	1	0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>246,217.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>246,217.1</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд төрийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хүн томилогдсон байна	1	0	-	-	-	-	1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>0</b>